

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 27-ны өдөр

Дугаар

БА-067/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 28.0м*15.0м, 72 (далан хоёр) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/06/02 огноо, 0012849 дугаар, БАЗГ2023/286;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар SA-01/2020;

2.3 Захиалагч: Монгол Улсын иргэн Гурван бэрх овогтой Гүррагчаа эцгийн нэр, Отгонбаяр нэр, ЦА78012017 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Энканто-2, 208 байр, 26 тоот, 99116670 холбоо барих утас;

Гурван бэрх старс ХХК оноосон нэр, 9011818415 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6575501 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Их монгол улс, Хансвилл, 104, 1-1006 тоот, 99116670 холбоо барих утас, otgo6670@yahoo.com цахим хаяг;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Вестерн консол ХХК оноосон нэр, 9011260024 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5446961 регистрийн дугаар, БУ11-1021/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р бичил хороолол, 6-А-103 тоот, 88110235 холбоо барих утас;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: ДЖ трейд ХХК оноосон нэр, 9011130034 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2601141 регистрийн дугаар, БУ12-323/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Эрдэнэтолгой, 40-224 тоот, 96653930 холбоо барих утас;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Сийз архитектуртс ХХК оноосон нэр, 9011186029 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5291615 регистрийн дугаар, 3Т11-922/19 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 55-364 тоот, 95950508 холбоо барих утас;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчид үйлчилэх төв-17 оноосон нэр, 2117118 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 37 дугаар хороо, Өрнөх хороолол, 9а байр, 70005454 холбоо барих утас, www.osnaaug.ub.gov.mn цахим шуудангийн хаяг;

Гурван бэрх старс ХХК оноосон нэр, 9011818415 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6575501

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Их монгол улс, Хансвилл, 104, 1-1006 тоот, 99116670 холбоо барих утас, otgo6670@yahoo.com цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг


- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн байгуул хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
 - Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар 28.0м*15.0м, 72 (далан хоёр) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;



б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:


- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 28.0м*15.0м, 72 (далан хоёр) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороо, Гурван бэрх старс ХХК-ийн захиалгатай
Үйлчилгээтэй 72 айлын орон сууц



Комиссын дарга:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Иргэн Г.Отгонбаяр


(Г.Отгонбаяр)

Гурван бэрх старс ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(Г.Отгонбаяр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 39 ДҮГЭЭР ХОРОО, ИРГЭН Г.ОТГОНБАЯР,
ГУРВАН БЭРХ СТАРС ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 72 АЙЛЫН
ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороо, иргэн Г.Отгонбаяр, Гурван бэрх старс ХХК-ийн захиалгатай зорьтой 12 давхар, 28.0м*15.0м, үйлчилгээтэй 72 айлын үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхарын хурлын танхимд 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр 09:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

- | | | |
|----|---|---|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: Гурван бэрх старс ХХК-ийн хуулийн зөвлөх | Р.Пүрэвнямсүрэн |
| 3 | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Б.Шинэжаргал |
| 4 | Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | З.Очирпүрэв |
| 5 | Барилга хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 6 | Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн ЗТТ-ийн ахлах инженер | Б.Оргил |
| 7 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер | Б.Цэрэннадмид |
| 8 | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн технологийн удирдлага төлөвлөлтийн газар, чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Н.Даваадэмид |
| 9 | Ус сувгийн удирдах газрын шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Ө.Шинэцэцэг |
| 10 | Онцгой байдлын ерөнхий газрын зураг хяналтын тасгийн дарга Дэд хурандаа | Б.Мягмаржав |
| 11 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын архивч | Б.Оюунжаргал |
| 12 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын ХҮТ-17-ийн ахлах инженер | Г.Сүхжаргал |
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Болормаа
С.Энхбаяр |
| 14 | Зураг төслийн Сийз архитектс ХХК-ийн захирал | Барилга байгууламжийг ашиглалтанд оруул Б.Занабазар |
| 15 | Гүйцэтгэгч Вестерн консол ХХК-ийн инженер | |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороо, иргэн Г.Отгонбаяр, Гурван бэрх старс ХХК-ийн захиалгатай зорьтой 12 давхар, 28.0м*15.0м, үйлчилгээтэй 72 айлын орон сууцны зориулалттай барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Ашиглалт хариуцах Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын ХҮТ-17 -ийн ахлах инженер **Г.Сүхжаргал:**

- Айлуудын коллекторын хайрцаг хийх
- Даралт бууруулах хаалтанд толгой хийх
- Нөөцийн савыг БУШ-с холдуулах, тусгаарлах
- Айлуудын босоо шугаманд засвар үйлчилгээ хийх ревиз гарган өгөх
- Узэлийн хэсэгт орох нөхцөлийг бүрдүүлэх
- Айл өрх болон барилгын бичиг баримт бүрдүүлж өгөх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч Вестерн консол ХХК-ийн инженер **Б.Занабазар:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Сийз архитектур ХХК-ийн захирал **С.Энхбаяр:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч Гурван бэрх старс ХХК-ийн захирал **Г.Отгонбаяр:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Болормаа:**

- ХБИ-н авто зогсоолд босоо тэмдэглэгээ хийх
- Явган хүний замд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг стандартын дагуу төлөвлөж хийх
- Барилгын 4-н буланд рампыг стандартын дагуу төлөвлөж хийх
- Үүдний налуу замд 2 талдаа ижил бариул хийх
- Барилгын урд буланд байгаа шатанд налуу зам төлөвлөх
- Үйлчилгээний төвийн АЦӨ-д ХБИ, өндөр настанд зориулсан тусгай тоноглолоор тоноглох

- Цахилгаан шатнуудад зарлан мэдээллэгч буюу давхар зарлагч суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормчлолын сангийн төлбөр төлөх;
- Гадна фасад, В1 гадна шатны хаалт шил зэрэг дутуу ажил гүйцээх
- Цоклын цонхны гадна хамгаалалт хийх
- Техникийн давхрын өөрчлөлт, 1-р давхрын өөрчлөлтийн зураг төслийг баталгаажуулах /магадлалаар оруулж хянуулах/
- Гадна тохижилт ногоон байгууламжийг батлагдсан ЕТ дагуу гүйцэтгэх
- Зоорийн давхрын үйлчилгээний талбайд батлагдсан зураг төслийн дагуу АЦӨ төлөвлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Б.Оюунжаргал:**

- ЗГ-н 212-р тогтоолоор барилга байгууламж ашиглалтад оруулах дүрмийн 5-р хавсралтад заасан жишиг жагсаалтын дагуу баримтаа бүрэн бүрдэлтэй өгөх
- АЕГ-н даргын 2023 А/57 тушаалаар батлагдсан зураг төсөл техникийн баримттай ажиллах зааварыг мөрдөж танилцах танилцах
- Хувийн хэрэг зөв бүрдүүлж бүрэн бүрдэлтэй өгөх
- БУ-н тэмдэглэл дэвтэр гарчиглах
- Барилгад хэрэглэсэн бараа материал гарал үүсэл чанарын гэрчилгээ С/Ш дүн сертификат үдэж хавтаслан д/товъёг хийж эх хувиар өгөх
- Ил далд ажлын актийг ажлын үе шатаар бүрэн бүрдэлтэй д/товъёг хийж эх хувиар өгөх
- Ажлын болон өөрчлөлт гүйцэтгэлийн зургийг баталгаажуулан эх хувиар өгөх
- Ажлын зураг болон үндсэн баримтын эх хувийг улсын архивд хүлээлгэж өгөх
- Хувийн хэрэг болон үндсэн баримтад дотоод товъёог үйлдэж, хуудас дугаарлаж заавар журмын дагуу цэгцлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын зураг хяналтын тасгийн дарга Дэд хурандаа **Б.Мягмаржав:**

- Барилгын 1-р давхрын гүйцэтгэлийн зураг гаргаж зохиогч баталгаажуулах
- Орон сууцны галын дотуур даралтат усны цэг "ГК"-г байнгын ашиглалтад оруулах
- Давхруудын шатны хонгилийн хаалганд өөрөө хаагдагч тоноглолоор тоноглох
- Гал түйрийн үеийн утаа зайлуулах, агаар өгөх системийн давхруудад агаар өгч байгаа болон утаа сорж буй хүчин чадлыг хэмжигч багажаар / нөхөж шалгах, цахилгаан шаттай автомат холболт хийх
- Техникийн давхрын хүчин чадал нэмсэн, 12 давхрын 2 сууцанд өөрчлөлт хийгдсэн байна. Зохиогч зураг гарган баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер

Ө.Шинэцэцэг:

- Цэвэр усны шинжилгээ өгөх
 - Нөөцийн савны ус юүлэх шугамын усыг зайлуулах трап хийх
 - Нөөцийн савыг стандартын дагуу угааж ариутгах
 - Гадна цэвэр усны шугам дулаалах
 - Бохир усны худгуудыг дулаалж шат хийх
 - Нөөцийн савыг БУШ-с холдуулах, тусгаарлах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер

Б.Цэрэннадмид:

- ЕОС, давхрын ХС-дад хаяг бичиглэл хийж схем байршуулах
 - Үйлчилгээний төв, гэрэлтүүлгийн самбаруудыг газардуулгын хүрээнд холбох
 - ЕОС-н ерөнхий тоолуур, айл өрх, ү/төвийн тоолуурыг Т/Н дагуу ухаалаг тоолуураар солих
 - Гадна цахилгааны дэд өртөө, ЦДКШ-г хангагч байгууллагад шилжүүлэх хүсэлт өгөх
 - 12 давхрын дүфлекс айлуудын дутуу тоноглолуудыг гүйцээх
 - Үйлчилгээний төвийн/1 давхар/ дутуу ажлыг гүйцээж фото зургаар баримтжуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн ЗТТ-ийн ахлах инженер **Б.Оргил:**

- Гадна шугам дулаалга хийх
 - Айлуудын коллекторын хайрцаг хийх, халаах хэрэгсэл дээр термостат вентиль суурилуулах
 - Халаалт алчуур хатаагчийн босоо шугамын төгсгөлд хий авагч бүрэн угсрах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШАЛГА
ГАЗАР
ламжийг
улах комис

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал:**

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, ил далт ажлын акт, улаан журнал, бетоны бат бэхийн шинжилгээний бичиг үе шат бүрээр үзүүлэх
- Лифттэй холбоотой магадлан, улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтийг шалгуулах
- Зураг төсөлд зохиогч, зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн гаргаж ирүүлэх
- Айлуудын хаалганы цоож бариул хийх
- Дутуу гүйцэтгэсэн заслын ажлыг бүрэн дуусгах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна огтолгооны худгийн шугамуудыг бүрэн дулаалга хийж, туузаар ороох
- Нөөцийн савны ус юүлэх шугамын усыг зайлуулах трап хийх
- Зоорийн давхар болон айлуудын коллекторын хайрцагууд хийх

- 1-р давхарт өөрчлөлт оруулсан хэсгийн ХАС-н өөрчлөлтийн зураг шалгуулах, өрөөнүүдийн засал болон шугамуудын угсралтыг гүйцэд дуусгах, авторын дүгнэлтэд өөрчлөлтийг тусган бичих
- Давхруудын тоолуур болон халаалтын коллекторыг хаягжуулах
- Айлуудын босоо шугаманд засвар үйлчилгээ хийх ревиз гарган өгөх
- Халаалт алчуур хатаагчийн босоо шугамын төгсгөлд хий авагч бүрэн угсрах
- Дээвэр дээрх үнэр гаргагч дулаалга хийх
- Техникийн давхрын өөрчлөлтийн зураг шалгуулан авторын нэгдсэн дүгнэлтэд тусгуулах
- Нөөцийн саванд ариутгал хийлгэн ундны усанд шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн технологийн удирдлага төлөвлөлтийн газар, чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Барилгын оролтын хоолойн амалгааг хийж гүйцээх
- Давхрын самбар дахь кабел шугамын бэхэлгээг хийж гүйцээх
- Зоорийн давхар дахь кабель шугамын тавиур болон техникийн өрөөнд хаяг бирк зүүж хаягжуулах
- Камерын хяналтыг харуул болон жижүүр дээр хянах боломжоор хангах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт гаргах
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гаргах албан тоот ирүүлэх
- Өөрчлөлтийн зураг батлуулж хянуулах
/техникийн давхар, дуплекс, өрөө зохион байгуулалт г.м/ үйлчилгээ
- Шатны хонгилын шатны бариулыг зурагт тусгагдсанаар гүйцэтгэх
- Тагтны хаалга доод хэсэг шилээр гүйцэтгэснийг зургийн дагуу болгох
- Гадна автомат хаалтыг буулгах
- Батлагдсан ЕТ-ний дагуу тохижилт, ногоон байгууламжийг хийж гүйцэтгэх
- Хүчин чадлыг өөрчилсөнд тайлбар албан тоот ирүүлэх /зохиогч, захиалагч нар/ В1 авто зогсоол г.м

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороо, иргэн Г.Отгонбаяр, Гурван бэрх старс ХХК-ийн захиалгатай зоо12 давхар 28.0м*15.0м, үйлчилгээтэй 72 айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Комиссын дарга:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн
хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



А.Мөнгөн

Тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга:

Гурван бэрх старс ХХК-ийн

Хуулийн зөвлөх



Р.Пүрэвнямсүрэн

